

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии



РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей



МЕЖДУНАРОДНАЯ
АССОЦИАЦИЯ
МОНГОЛОВЕДОВ



КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: РУКОПИСНЫЕ И АРХИВНЫЕ СОБРАНИЯ

V

**Международная конференция
при поддержке Президента Монголии**



19-21 апреля 2021 г. Санкт-Петербург

Сборник докладов

Санкт-Петербург- Улан-Батор
2023

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Ответственный редактор: Академик С.Чулуун
Редакторы-составители: доктор филол. наук И.В.Кульганек
доктор (Ph.D) Н.Хишигт
кандидат филол. наук Д.А.Носов

Культурное наследие монголов: Рукописные и архивные собрания. Сборник докладов V международной научной конференции. 19-21 апреля 2021 г. Санкт-Петербург, Россия. СПб.-УБ., 2023 г. -...с.,

Сборник представляет собой собрание докладов V международной научной конференции "Культурное наследие монголов: рукописные и архивные собрания", организованной Институтом восточных рукописей РАН, Институтом истории и этнологии МАН и Международной Ассоциацией монголоведов в г.Санкт-Петербург, 19-21 апреля 2021 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Институт восточных рукописей РАН, 2023 г

© Институт истории и этнологии МАН, 2023 г.

© Международная ассоциация монголоведов, 2023 г

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн



ОХУ-ЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн



ОЛОН УЛСЫН МОНГОЛ
СУДЛАЛЫН ХОЛБОО



МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

V

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор
зохион байгуулсан



Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2021 оны 4 сарын 19-21
Санкт-Петербург хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург- Улаанбаатар
2023

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Хариуцлагатай редактор:
Эмхтгэгч-редактор:

Академич С.Чулуун
Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек
Түүхийн ухааны доктор (Ph.D) Н.Хишигт
Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн Д.А.Носов

Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга - V. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. 2021 оны 4 дүгээр сарын 19-21. ОХУ, Санкт-Петербург хот. Санкт-Петербург-Улаанбаатар., 2023 г. ... тал.

Тус эмхэтгэлийг Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбооноос 2021 оны 4 дүгээр сарын 19-21-нд ОХУ-ын Санкт-Петербург хотноо хамтран зохион байгуулсан "Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга" 5 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдээр бүрдүүлэв.

Энэхүү хурлыг зохион байгуулах эх суурь нь архив, гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй монгол угсаатан ард түмнүүдийн хэл, түүх, угсаатны зүй, улс төр, соёлд холбогдох баримт материал болно.

Эмхэтгэлд монгол судлалын түүх, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, хээрийн шинжилгээний ангиудын тухай болон Монголын уламжлалт нийгэм, орчин үеийн амьдралын олон талт асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүдийг багтаав.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2023 г

© Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2023 г

© Олон улсын Монгол судлалын холбоо, 2023 г

MONGOLIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of History and
Ethnology



RUSSIAN ACADEMY OF
SCIENCES
Institute of Oriental
Manuscripts



INTERNATIONAL
ASSOCIATION FOR
MONGOL STUDIES



CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

V

**International Conference
Under the Patronage of the President of Mongolia**



April 19-21, 2021. St. Petersburg

Proceedings

St. Petersburg - Ulaanbaatar
2023

HHА 63.4
ДАА 930.1
М-694

Edited and compiled by

acad. S.Chuluun
D.Sc.(Philology) I.V.Kulganek,
Ph.D (History) N.Khishigt,
Cand.Sc.(Philology) D.A.Nosov

Cultural heritage of the Mongolis: manuscripts and archival collections. Papers of the V International Conference, April 19-21, 2021. St.Petersburg. St.Petersburg -Ulaanbaatar 2023, pages.

This is a collection of papers, presented at the Fifth International Conference organized by the the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences, Institute of History and Ethnology of the Mongolian Academy of Sciences and the International Association for Mongol Studies which was held in St. Petersburg on April 19-21, 2021.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples.

The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Institute of Oriental Manuscripts RAS, 2023 r

© Institute of History and Ethnology MAS, 2023 r.

© International Association for Mongol Studies, 2023 r

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ /

ӨМНӨХ ҮГ / ПРИВЕТСТВИЕ

Приветствие директора Института восточных рукописей РАН, член-корреспондента РАН И.Ф.Поповой	11
Монгол улсын ШУА-ийн ерөнхийлөгч, академич Д. Рэгдэлийн мэндчилгээ	13
Приветствие генерального секретаря международной ассоциации монголоведов, академика С.Чулууна	15
Монгол улсын Их хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангийн мэндчилгээ	
Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарын мэндчилгээ	

ИЛТГЭЛҮҮД / ДОКЛАДЫ

Г. Алтансүх.

Аноним Шибани Нāме дахь монгол хүний нэрийн зарим асуудалд

Э. Баярчимэг

Лхаарамба Агваандандарын найруулсан “Сарны гэгээн гэрэл” хэмээх
дохионы бичгийн нэгэн хувилбарын тухай

К. И. Бикмаева

Национальные программы по монгольской письменности
(монгол бичгийн үндэсний хөтөлбөр) как один из основных
документов в области языковой политики монголии

Л. Ганбат

Ибн Арабшах-ийн “Asāibu’l makdûr” зохиолд нүүдэлчдийн
байлдах арга, бодлогын тухайд өгүүлсэн нь

Л. С. Дампилова

Жанровое разнообразие архивных материалов Монгольской
экспедиции 1967 года

И. М. Захарова, М. В. Мандрик

Экспедиции М.Д. и Н.Д. Бутиных 1870 и 1881 гг. в Китай

И. В. Кульганек, Н. В. Захарова

Фотографии о монголии и монголах в Институте восточных
рукописей РАН

Э. Мөнхцэцэг

Монгол улсын Үндэсний Номын сан дахь нэгэн монгол-манж
толь бичгийн тухай

Б. Нацагдорж, О.Оюунжаргал

“Хүрээний хэргийн зүй (庫倫事宜)” хэмээх сурвалжийн тухай

Д. А. Носов

Россыпи документов В. А. Казакевича: полевой дневник 1925 г.

Р. Ю. Почекаев

Правовые воззрения монголов в пословицах и поговорках

Э. Пүрэвжав

Хэлмэгдсэн бүтээлүүд: 1938 оны V сарын 12-ны өдрийн акт бичиг

Т. Д. Скрынникова

Сакральность правителя и его ритуальные функции
(По материалам анонимной Altan tobči)

М. В. Федорова

Этнографическая коллекция Д.Э. Ухтомского, привезенная из
экспедиции в Северную Монголию (1910 г.)

А. Д. Цендина

Гадания на кубиках (по материалам квартиры-музея
Ц.Дамдинсүрэна и коллекции Р.Отгонбаатара)

Б.-Х. Б. Цыбикова

Локальные особенности устных нарративов бурят о Шоно баторе

С. Чулуун, Н.Хатанбаатар

Берестяная грамота, обнаруженная из раскопок монастыря в
Монгольском гоби

Т. И. Юсупова

Монгольский ученый комитет в отзывах российских исследователей

РЕЗОЛЮЦИЯ

СВЕДЕНИЯ ОБ АВТОРАХ

ЗОХИОГЧДЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

DOI 10.48612/IVRRAN/fth2-v13r-a8dm

Э. Баярчимэг

**ЛХААРАМБА АГВААНДАНДАРЫН НАЙРУУЛСАН
“САРНЫ ГЭГЭЭН ГЭРЭЛ” ХЭМЭЭХ ДОХИОНЫ БИЧГИЙН
НЭГЭН ХУВИЛБАРЫН ТУХАЙ**

Олноо Алишаа лхаарамба, Дандар лхаарамба хэмээн алдаршсан, их эрдэмтэн Агваандандарын 1838 онд найруулсан төвөд үсгийн цагаан толгойн үсэг дараалуулсан “Нэр утгыг тодотгогч сарны гэгээн гэрэл хэмээгдэх дохионы бичиг оршвой” (товч нэр: “Сарны гэгээн гэрэл”) хэмээх төвөд-монгол хоёр хэлний дохионы бичиг нь зохиогдсон цагаасаа хойш модон бараар төдийгүй мөн гар бичмэл хэлбэрээр ч тархсан байдаг. Тэгвэл ийм гар бичмэлийн нэгэн хувилбар болох төвөд-ойрад гар бичмэл эхийг Баруун хойтын үндэсний их сургуулийн багш Б.Мөнхөө, Монгол улсын боловсролын их сургуулийн багш На.Сүхбаатар нар 2018 онд Улаанбаатар хотноо гэрэл зургаар эрхлэн хэвлүүлж олон нийтэд танилцуулан судалгааны эргэлтэд оруулжээ. Уг хувилбар нь шаашиг номын хүрээнд тухайн уншигч, хэрэглэгчийн мэдлэгт тохируулж төвөд үсгээр ойрад аялгууг галиглан тэмдэглэснээрээ бусад хувилбараас онцлог ялгаатай байна. Зохиогч тус өгүүлэлдээ “Тод номын гэрэл төв”-өөс 2018 онд хэвлэн гаргасан уг төвөд-ойрад гар бичмэл “Сарны гэгээн гэрэл” толь бичгийн хэлний зарим онцлогийн тухай дурджээ. Мөн Шинжлэх ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны тасгийн “Монгол номын хөмрөг”-т хадгалагдаж буй А-0975 дугаартай “Ner-e udqa-a-yi todudqayçi saran-u gegen gerel kemegdekü dokiyan-u bičig orusiba” хэмээх эхийн төвөд үсгээр галигласан зарчмыг дээрх гар бичмэл хувилбартай харьцуулан үзжээ.

Түлхүүр үг: Толь бичиг, төвөд-ойрад хувилбар

E.Bayarchimeg

**ON A VERSION OF TIBETAN AND MONGOLIAN DICTIONARY
“BRIGHT MOONLIGHT” BY LHAARAMBA AGVAANDANDAR**

Tibetan-Mongolian dictionary called as “Ner-e udqa-yi todudqayçi saran-u gegen gerel kemegdekü dokiyan-u bičig orusiba” (briefly, “Bright Light of Moon”) that was written in 1838 by Agvaandandar, a great scholar known as “Alshaa lharamba” or “Dandar lharamba” had been published in wooden prints and manuscripts since its publication time. A version of the manuscripts was

published as photograph by Munkhuu B and Sukhbaatar Na in Ulaanbaatar in 2018. This version is peculiar in which Oirat dialect words were transcribed by Tibetan script adjusting to audience and readers.

*The author compares this version to the wooden print version kept numbered as A-0975 (Beijing print, 62p, 10*51.5, 4) in Mongolian book storeroom of the Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences and describes their phonetic, orthographic and morphologic features.*

Key words: Dictionary, Tibetan-Oirat version

Монголчуудын толь бичиг зохион хэрэглэж ирсэн түүхийг нэхэн үзвэл их л эртний улбаа гарах бөгөөд (Түвшинтөгс, 2008: 113) монголчууд бид эх хэлээрээ болон бусад хэлээр толь бичиг найруулж байсан баялаг түүхтэй, тэр дундаа төвөд бичгийн хэлээр толь найруулсаар ирсэн арвин туршлагатай ард түмэн билээ.

Агваандандарын найруулсан “Сарны гэгээн гэрэл” дохионы бичгийг эрдэмтэд өөр өөрсдийн бүтээлдээ дараах байдлаар тодорхойлон үнэлэлт дүгнэлт өгсөн байдаг.

“Гүн Гомбожавын даягийг бодвол нэлээд олон үгтэй бөгөөд үг үсэг нь алдаа мадаггүй, төвөд үсгийн дэс дараагаар зохиосон, орчуулга ч сайн. Нэр үгс ба үйл үгийн үндсийг зөвөөр гаргаж, нэр үгсийн утгыг орчуулгаар тодотгон харуулж чадсан болой” (Дорж, 2009: 109-110). “Төвөд хэлний үгсийн сангийн нэгжийн цөм утгыг монгол хэлнээ чадамгай буулган дохиолсон хамгийн шилдэг толь бичгийн нэг болж чадсан нь хожим хойшид, өнөө ч суралцагч оюутны эрэл хэрэгцээг хангасаар буй нь зохиогчийн хэрэг зориг бүрэн биелснийг илтгэнэ” (Сүхбаатар нар, 2018: VIII). “Толь зүйн чиглэлээр Агваандандар «Сарны гэрэл» хэмээх түм орчим үгийг багтаасан алдарт толь бичгээ туурвисан нь Ар, Өвөр монгол, ойрад, буриад мэргэдийн ширээний ном болсоор ирсэн төдийгүй өнөө цагийн хэл соёл судлаачдын чухал гарын авлага болж байна” (Бүрнээ, 2018: 6). “Агваандандар лхаарамба нь гүн Гомбожавын зохиосон дохионы бичигт буй дутуу үгсийг нөхөн гүйцээх замаар түүнээс хавьгүй олон үгтэй бие даасан дохионы бичиг найруулсан байна” (Даваасүрэн, 2018: 17) гэх мэтээр дүгнэсэн байдаг. Энэ мэт Агваандандарын “Сарны гэгээн гэрэл” хэмээх хоёр хэлний дохионы бичиг нь одоо ч судлаачдын төвөд-монгол толь бичиг найруулах үндсэн гарын авлагын нэг болсоор байгааг эрдэмтэн судлаачид дуу нэгтэйгээр хүлээн зөвшөөрдөг байна.

“Сарны гэгээн гэрэл” хэмээх хоёр хэлний дохионы бичгийн нэгэн хувилбар болох төвөд-ойрад гар бичмэлээр байгаа эхийн хэлний баримт сэлтийг судлах нь монгол хэлний ойрад аялгууны авиа зүй, үг зүй, үгийн сангийн хувьсал хөгжил хийгээд тухайн үеийн ойрад аялгууны онцлог ямар байсан зэргийг судлахад нэлээд сонирхолтой эх хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй юм.

Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны тасгийн “Монгол номын хөмрөг”-т хадгалагдаж буй “Сарны гэгээн гэрэл” хэмээх барын эхийн эхний 21 нүүрэнд төвөд үсгээр монгол үгийг галиглан хадсан байгааг ажиглан тэдгээрийн үсэг зүй, авиа зүй, үг зүйн зарим онцлогийн талаар харьцуулан авч үзье.

Монголд эрт дээр үеэс уламжлан хөгжиж ирсэн аман бичгийн хэлний байдал хэрхэн өөрчлөгдөж энэхүү аман бичгийн хэл нь бичгийн хэл, ярианы хэл хоёрын харилцан нөлөөлөх явцад хэрхэн хөгжиж ирсний түүхийг судлахад бүр ч анхаарлыг татах гойд үнэтэй хэрэглэгдэхүүн болж өгнө (Пагба, 2009: 221) хэмээн төвөд үсгээр үгчилсэн монгол ном зохиолын ач холбогдлын талаар өгүүлжээ.

Өнгөрсөн зууны гучаад он хүртэл Монгол газар буддын боловсролыг олгох зорилгоор өдий төдий хүрээ хийдүүд байгуулагдаж, тэнд төвөд хэлээр сургалт явуулдаг байсны улмаас төвөд бичгийн хэлний хэрэглээ өргөжсөн ажээ. Хүрээ хийдэд эрдэм ном суралцаж байсан хүмүүс өөр хоорондоо бичгээр харилцах, төвөд хэлийг сурч судлах, бурхны сургаал номлолыг бүрэн ухаарч ойлгоход монгол хэлээр бичиж тэмдэглэх хэрэгцээ заавал ч үгүй гарч ирэх нь мэдээж юм. Чухамхүү хэрэгцээг төвөд үсгээр монгол хэлийг үгчлэн буулгах замаар хангаж байжээ (Сүхбаатар нар, 2018: VIII) хэмээн дүгнэсэн байна. Тэгвэл эрдэмтэн Т.Пагба Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хуралд хэлэлцүүлсэн илтгэлдээ: “... Төвдийн бичгийн хэлэнд нэвтэрхий мэргэжсэн монгол хүн хэдэн арван жил төвдийн бичиг зохиолд нас биеэ зориулаад, монгол бичгээ сурахыг хичээх нь цөөн байв. Төвөд цагаан толгой, зөв бичих дүрмийн наад захын томьёолол төдийхнийг мэдсэн тийм лам нараас аваад төвөд бичгийн хэлэнд гүнзгий мэргэжсэн бичгийн хүмүүст ч хүртэл харилцааны гол хэрэглүүр болсон хэлээ бичгээр илэрхийлэх шаардлага аяндаа гарч ирсэн аж. Жишээ нь, төвөд орчуулгын ном үзэхэд, төвөд хэлний үг, хэллэгийн утга учрыг мартахгүйн тул, орчуулгыг нь хадахдаа монгол бичиг мэдэхгүй учир төвөд үсгээр үгчилж тэмдэглэх нь аргагүй шаардагдав. Ийнхүү монгол үгийг төвөд үсгээр галигчлан бичих явдал урсгалаар гарч ирсэн бөгөөд

түүнийгээ “үгчлэх” гэж нэрлэдэг байв” хэмээн дурджээ. Өөрөөр хэлбэл төвөд үсэг бичиг сурсан, монгол бичиг үсгээ сураагүй лам нарт зориулсан төвөд үсгээр үгчлэн буулгасан дохионы бичгүүд болон бусад ном зохиол нэн олон гарсаар байсан тухай илтгэлдээ дурджээ.

“Нэр утгыг тодотгогч Сарны гэгээн гэрэл хэмээгдэх дохионы бичиг оршвой” толь бичгийн төвөд-ойрад гар бичмэл хувилбарын тухай

Баруун хойтын үндэсний их сургуулийн багш Б.Мөнхөө, Монгол улсын боловсролын их сургуулийн багш На.Сүхбаатар нарын 2018 онд гэрэл зургаар эрхлэн хэвлүүлсэн «Алшаа лхаарамба Агваандандар “Нэр утгыг тодотгогч сарны гэгээн гэрэл хэмээх дохионы бичиг оршвой»» номд танилцуулснаар:

Номын нэр: ༄༅།བརྒྱལ་ཡོན་མེད་དོན་གསལ་བར་བྱེད་པའི་སྐྱེ་བའི་འོད་སྤྲེང་ཞེས་བྱ་བ་བརྒྱགས་སོ།

Хэмжээ: 35x10.5 см ХЭМЖЭЭТЭЙ

болгомол цаасан дээр 3 мөрөөр, хар бэхээр бичсэн төвөд-ойрад монгол гар бичмэл, 93 хуудастай байна.

Төгсгөлийн үг: төвөд үсгээр ойрад аялгуугаар – “Өгүүлэгдэхүүн утгын махны өнгийг үл халхлах, өгүүлэгч үгийн сайн үүнийг, элдэв үзгийн (үсгийн) олон ширхгийг эвлүүлж, билгийн хуруугаар сайтар нэхэж бүтээв би алимад дохио барилдуулах ёсонд эс мэргэжвээс, хоёр ёсны ялгалд мунхрах болоод, мэргэдийн сууринд суухуйяа зохисгүй тул, тэр ёсонд үл тэсэхдээ энэ учирт оролдвой. Энэ нь дуришилтны эрэл хангагч, сайн бумба хийгээд, сайн зарлигийн далайн сонин юмыг үзэх нүдэн, дохио утгын сайхан царай тодрогч толь бөгөөд, элдэв зүйлийн нэрийтгэлийг гийгүүлэгч

Зураг 1. “Сарны гэгээн гэрэл”-ийн
төгсгөлийн үгийн хэсгээс

зул мөн, аяа нэр утгыг тодотгогч сүр жавхлангаар, мунхгийн харанхуйг нэгэн агшинд үлдэгч, нарны гэрлээс ч асар тодорхой, чихний чимэг

үүнийг, бүгдээр дууны баригч байн, гийгүүлэх цог болгогтун, боловч хамаг номын магад үгсэд, очтой гэгээн тод билиг олсонгүйн тул, мэдэлгүй буруу номносон гэмээр халдсан болбоос, энэрэн хүлцэж шамдлаар ясан (засан) ажаамуй, үүнд хичээсэн буяны мэргэн их худалдаачны ноён тэр” гэж орчуулаад цааш орчуулалгүй орхисныг На.Сүхбаатар нарын гэрэл зургаар хэвлүүлсэн бүтээлд кирилл монгол болон тод монгол үсгээр орчуулан гаргасан байна.

**“Сарны гэгээн гэрэл” хэмээх төвөд-ойрад
гар бичмэл толь бичиг дэх хэлний зарим онцлог**

Нэг. Уг дохионы бичигт ойрад нутгийн аялгууны үгс элбэг тохиолдоно. Монгол хэл, аялгууны хөгжил хувьслыг бусад нутгийн аялгууны жишээ баримт, хэрэглэгдэхүүнтэй харьцуулан судлах нь ихээхэн ач холбогдолтой байдаг. Тиймээс бидний авч үзэж буй энэхүү төвөд-монгол дохионы бичиг нь монгол үгийг төвөд үсгээр үгчлэн буулгахдаа ойрад аялгууны дуудлагыг баримталж бичсэн байх ба тухайн нутгийн аялгууны үгс нэн элбэг тохиолдож байна. Жишээлбэл:

<u>Төвөд-монгол бар СГГ:</u>	<u>Төвөд-ойрад монгол СГГ:</u>	<u>Халх аялгуунд:</u>
ᠬᠢᠲᠦᠭᠦᠨ	ᠬᠢᠲᠦᠭᠦᠨ (хийтэн)	хүйтэн
ᠥᠨᠴᠢ	ᠥᠨᠴᠢ (өнч)	өмч
ᠵᠠᠰᠠᠬ	ᠵᠠᠰᠠᠬ (ясах)	засах
ᠬᠦᠮᠡᠨ	ᠬᠦᠮᠡᠨ (хүмэн)	хүн
ᠢᠯᠴᠢ	ᠢᠯᠴᠢ ¹ (нилч)	илч
ᠦᠰᠦᠭ	ᠦᠰᠦᠭ (үзүг)	үсэг
ᠵᠠᠰᠠᠮᠠᠯ	ᠵᠠᠰᠠᠮᠠᠯ (ясмал)	засмал
ᠬᠠᠯᠵᠠᠨ	ᠬᠠᠯᠵᠠᠨ (галзан)	халзан
ᠭᠤᠰᠠᠭ	ᠭᠤᠰᠠᠭ (госон)	гутал
ᠭᠦᠷᠢᠯ	ᠭᠦᠷᠢᠯ (гуяр)	гурил
ᠢᠯᠦᠭᠦ	ᠢᠯᠦᠭᠦ (үлүү)	илүү
ᠮᠠᠭᠠᠭᠠᠷ	ᠮᠠᠭᠠᠭᠠᠷ (манагар)	маргааш
ᠲᠠᠭᠠᠨᠠᠢ	ᠲᠠᠭᠠᠨᠠᠢ (тангнай)	тагнай
ᠢᠰᠢᠭᠡᠭᠡ	ᠢᠰᠢᠭᠡᠭᠡ ² (ишгээ)	эсгий

¹ Монгол хэлний их тайлбар тольд “нилчгэнэх” гэж үг халуун илч, уур амьсгал төөнөх гэж тайлбарласан байна.

² Ж.Цолоо (1988) “IŠGÄ” гэж галиглаад эсгий гэжээ. Г.Гантогтох (2011) “heyī” гэж тэмдэглэсэн байдаг. С.Мөнхсайхан (2020) МНТ-ны 202§ “sisgei” (x.1161) хэмээн галиглаад жишээгээр харуулжээ.

ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠶ᠋ᠢᠨ	ᠬᠠᠢᠰᠤᠨᠢ	тогооны
ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠶ᠋ᠢᠨ	ᠶ᠋ᠢᠨᠠᠨ	засал
ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠶ᠋ᠢᠨ	ᠶ᠋ᠢᠨᠠᠨ	эрүү
ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠶ᠋ᠢᠨ	ᠬᠠᠢᠰᠤᠨᠢ	хул (ухаа)шаргал

ГЭХ МЭТ.

Төвөд-ойрад гар бичмэл хувилбараас харахад, “Үгчилсэн дохионы бичиг, дүймэнгийн зүйл нь монгол хэлний нутгийн аялгуу судлах талаар сонин зүйл болохыг тэмдэглэлтэй” (Дорж, 2009: 96) гэсэнчлэн уг гар бичмэл нь монгол хэлний ойрад нутгийн аялгууны үгийн санг судлахад маш сонирхолтой эх хэрэглэгдэхүүн болж өгч байна.

Хоёр. *Уг дохионы бичигт авиа тонгорч³ бичсэн нь бий.* Монгол хэлэнд авиа тонгорох нь нэн элбэг. Авиа зүйд үүнийг авиа, үе тонгорох ёс хэмээнэ. Үг бүтээвэр дэх хоёр авиа харилцан байраа сольсныг авиа тонгорох гэнэ. Авианы тонгорлыг зэрэгцэн ба алгасан тонгорох, эгшиг ба гийгүүлэгч авиа тонгорох гэх мэтээр ангилж болно. Монгол бичгийн хэлний үе, үгийн адагт орж байсан богино эгшгүүд тонгорч, гийгүүлэгчтэйгээ байраа сэлгэсэн нь нэлээд бий. Жишээ нь: *terge(n) > terëg, torγ-a > toröγ, silbe > šilëw* (Санжаа нар, 2008: 197) гэх мэт. Тэгвэл энэхүү тонгорох ёс уг дохионы бичигт ч туссан байдаг. Жишээлбэл:

<i>Төвөд-монгол бар СГГ: Төвөд-ойрад монгол СГГ:</i>	<i>Халх аялгуунд:</i>
ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠠᠨᠠᠨᠠᠨ
ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠠᠨᠠᠨᠠᠨ
ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠠᠨᠠᠨᠠᠨ

гэх мэтээр авиа, үе тонгорч тухайн нутгийн аялгууны үгсээр монгол хэл баяжиж байдгийг харж болно.

Гурав. *Төвөд бичгийн уламжлалыг баримтлан хурааж, зүүж бичсэн зүйл нэлээд түгээмэл ажиглагдана.* Жишээ нь:

1. “М” үсгийг хурааж бичсэн нь (ᠮ): *ᠮᠠᠨᠠᠨ* (уншлага), *ᠮᠠᠨᠠᠨ* (тулам), *ᠮᠠᠨᠠᠨ* (хадам), *ᠮᠠᠨᠠᠨ* (чадамгай), *ᠮᠠᠨᠠᠨ* (бардам) гэх мэт.
2. “Р” үсгийг зүүж бичсэн нь (ᠷ): *ᠷᠠᠨᠠᠨ* (эрдэнэ), *ᠷᠠᠨᠠᠨ* (эрэх), *ᠷᠠᠨᠠᠨ* (гэнэтэр), *ᠷᠠᠨᠠᠨ* (тархсан), *ᠷᠠᠨᠠᠨ* (тархи) гэх мэт.

³ Нэг ухагдахууныг нөгөө ухагдахуунтай шүтэлцүүлж, нөгөө ухагдахуунаа түрүүчийн ухагдахуунтай солбиулан хэлэхийг тонгорол гэдэг ба энэхүү тонгорол хэмээхийг монгол хэл шинжлэлд хэд хэдэн янзаар нэрлэсээр ирсэн байна. Үүнд: Д.Ёндон “солбиулал”, Чой.Лувсанжав “өөрчлөл”, Ж.Баянсан “тонгорол”, М.Базаррагчаа “хөрвөл” гэх мэт.

3. “Ш” үсгийг зүүж бичсэн нь (ә): *Ш* (гишгэх) гэх мэт жишээ олон тааралдана.

Энэ мэтээр төвөд бичгийн соёлтой лам нар монгол хэлэнд үгчлэн буулгахдаа зүгээр нэг буулгасангүй монгол хэлнийхээ онцлог, хэв маягт тохируулан төвөд үсгээр үгчлэх зарчмыг хэвшүүлэн тогтоохоор оролдож байсан гэлтэй.

Дөрөв. *Монгол бичгийн хэлний уламжлалыг баримтлан бичсэн нь бий:* Жишээлбэл, ой. *Гурил*, мо. *ᠭᠦᠷᠢᠯ* (гурил), ой. *Цэмбэ*, мо. *ᠴᠡᠮᠪᠡ* (цэмбэ), ой. *Нугас*, мо. *ᠨᠦᠭᠠᠰ* (нугас), ой. *Үзэсгэлэн*, мо. *ᠦᠵᠡᠰᠭᠡᠯᠡᠨ* (үзэсгэлэн), ой. *Бадар*, мо. *ᠪᠠᠳᠠᠷ* (тагнай), ой. *Тавих*, мо. *ᠲᠠᠪᠢᠬ* (тавих), ой. *Айх*, мо. *ᠠᠶᠢᠬ* (айх), ой. *Хаана*, мо. *ᠬᠠᠠᠨᠠ* (хаана), ой. *Нүүр*, мо. *ᠨᠡᠭᠦᠷ* (нүүр) гэх мэт. Үүнээс гадна, монгол бичгийн хэлэнд үгийн эхэнд амьгүй бичдэг уламжлалт үсгийг өөрчилж дуудлагаар нь бичсэн онцлог харагдана. Жишээ нь: мо. *včir* (včir), ой. *o-čir* (o-čir), мо. *tngri* (tngri), ой. *teng-ge-ri* (teng-ge-ri), мо. *blam-a* (blam-a), ой. *la-ma* (la-ma), мо. *gkir* (gkir), ой. *kir* (kir) гэх мэтээр монгол бичгийн хэлээр уламжлалыг баримтлан буулгасан нь сонирхолтой байна.

Тав. *Үг зүй, үсэг зүйн зарим онцлог:* Монгол бичигт гарахын тийн ялгалын *-ača, -eče* хэмээн ялгадаг уг нөхцөлийг дээрх гар бичмэл сударт эр ба эм эгшигт үгэнд аль алинд нь *-eče* (ᠡᠵᠡ) нөхцөл дагуулжээ. Жишээлбэл: *Зуулгаас* (зуулгаас), *Тэндээс* (тэндээс) гэх мэт.

Монгол бичигт үйлдэхийн тийн ялгалын нөхцөлийг *-bar, -ber*, *-iyar, -iyer* хэмээн ялгаж бичдэгийг ойрад аялгуугаар тэмдэглэсэн уг гар бичмэлд эгшгээр төгссөн үгэнд эр, эм эгшиг үл харгалзан зөвхөн *-ber* (ᠪᠡᠷ) нөхцөл, гийгүүлэгчээр төгссөн үгэнд эр, эм эгшиг үл харгалзан зөвхөн *-iyer* (ᠶᠡᠷ) нөхцөл тус тус дагуулж бичжээ. Жишээлбэл: *Бачтай* (ачаар), *Алгуураар* (алгуураар), *Зарлигаар* (зарлигаар), *Зоригоор* (зоригоор), *Өвсөөр* (нүүдлээр), *Өвсөөр* (өвсөөр) гэх мэт.

Хамтрахын тийн ялгалын нөхцөлийг монгол бичигт *-tai, -tei*-ээр ялгадгийг уг гар бичмэлд эр эгшигт үгэнд *-тай, -той* (ᠲᠠᠢ, ᠲᠡᠢ), эм эгшигт үгэнд *-тэй* (ᠲᠡᠢ) нөхцөл залгасан байна. Жишээ нь: *Бачтай* (бачтай), *Бодтой* (бодтой), *Хөрстэй* (хөрстэй), *Өнгөтэй* (өнгөтэй) гэх мэт.

Энэ мэтээр дохионы бичгийг ойрад аялгуунд тохируулан дохиолохдоо зүгээр ч нэг үгчлэн буулгасангүй ба тод үсгийн дүрмийг тодорхой хэмжээнд баримтлан буулгасан нь илэрхий харагдана.

“Тод номын гэрэл төв”-өөс 2018 онд хэвлэн гаргасан төвөд-ойрад гар бичмэл “Сарны гэгээн гэрэл” болон ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны тасгийн “Монгол номын хөмрөг”-т хадгалагдаж буй А-0975 дугаартай “Ner-e udq-a-yi todudqayči saran-u

gegen gerel kemegdeckь dokiyan-u bičig orusiba” хэмээх хоёр эхийн төвөд үсгээр галигласан зарчмыг харьцуулж үзвэл хэд хэдэн сонирхолтой зүйл ажиглагдаж байна.

Хүснэгт 1.

Эгшигийн харьцуулал

Цагаан толгой	Төвөд үсэг	Жишээ				Кирилл
		Төвөд үсгээр монгол үгийг хадсан байдал				
		Барын хувилбарт		Ойрад хувилбарт		
а	ᠠᠨ	ᠠ	ᠠᠨᠠ	ᠠᠨ	ᠠᠨᠠ	алим
э	ᠡᠨ	ᠡ	ᠡᠨᠡ	ᠡᠨ	ᠡᠨᠡ	эрдэнэ
и	ᠢᠨ	ᠢ	ᠢᠨᠢ	ᠢᠨ	ᠢᠨᠢ	илэрхий
о	ᠣᠨ	ᠣ	ᠣᠨᠣ	ᠣᠨ	ᠣᠨᠣ	ороосон
у	ᠤᠨ	ᠤ	ᠤᠨᠤ	ᠤᠨ	ᠤᠨᠤ	урт
ө	ᠥᠨ	ᠥ	ᠥᠨᠥ	ᠥᠨ	ᠥᠨᠥ	төв
ү	ᠦᠨ	ᠦ	ᠦᠨᠦ	ᠦᠨ	ᠦᠨᠦ	үнэн үг

БАРЫН ЭХ				ОЙРАД МОНГОЛ ГАР БИЧМЭЛ ЭХ			
“У” эгшиг		“Ө” эгшиг		“У” эгшиг		“Ө” эгшиг	
ᠤ	ᠤᠨᠠᠨ	ᠥ	ᠥᠨᠠᠨ	ᠤᠨ	ᠤᠨᠠᠨ	ᠥᠨ	ᠥᠨᠠᠨ
	хусуур		mee		хусуур		mee

Тэгвэл төвөд-ойрад гар бичмэл “Сарны гэгээн гэрэл”-д урагшилсан “æ” эгшиг ба “œ” эгшигийг нарийн тэмдэглэн буулгасныг жишээгээр харуулбал дараах мэт байна. Жишээ нь: æli (æli), æmitʰaŋ (æmitʰaŋ), sœril (sœril), gœbi (gœbi) гэх мэтээр урагшлан урдуур хэлэгдэх байдлыг нарийн тэмдэглэж харуулжээ. Тэгвэл барын эхэд, дээрх байдлыг тусгасан эсэхийг харьцуулж үзэхэд урагшилсан эгшигийг тэгж нарийн тэмдэглээгүй байгааг харж болохоор байна. Жишээ нь:

<i>Төвөд-монгол бар СГГ:</i>	<i>Төвөд-ойрад монгол СГГ:</i>	<i>Халх аялгуунд:</i>
ᠪᠠᠷᠠᠭ	ᠪᠠᠷᠠᠭ	барилах
ᠪᠠᠷᠢᠬᠡ	ᠪᠠᠷᠢᠬᠡ	барих
ᠬᠠᠯᠤᠰ	ᠬᠠᠯᠤᠰ	хальс
ᠰᠠᠷᠢᠭ	ᠰᠠᠷᠢᠭ	сариу гэх мэт.

Хүснэгт 2.

Гийгүүлэгчийн харьцуулал

Цагаан толгой	Төвөд үсэг	Жишээ		
		Төвөд үсгээр монгол үгийг хадсан байдал		Кирилл
		Барын хувилбарт	Ойрад хувилбарт	
н	ᠨ	ᠨᠠᠭ	ᠨᠠᠭ	нөхцөл
нг	ᠨᠭ	ᠨᠭᠠᠭ	ᠨᠭᠠᠭ	сунган
ха, хэ	ᠬᠠ, ᠬᠡ	ᠬᠠᠭ	ᠬᠠᠭ	хөл
га, гэ	ᠭᠠ, ᠭᠡ	ᠭᠠᠭ	ᠭᠠᠭ	гар
д	ᠳᠠ, ᠳᠡ	ᠳᠠᠭ	ᠳᠠᠭ	дотор
т	ᠲᠠ, ᠲᠡ	ᠲᠠᠭ	ᠲᠠᠭ	тэгш
б	ᠪᠠ, ᠪᠡ	ᠪᠠᠭ	ᠪᠠᠭ	бие
м	ᠮᠠ, ᠮᠡ	ᠮᠠᠭ	ᠮᠠᠭ	маш
з, ж	ᠵᠠ, ᠵᠡ	ᠵᠠᠭ	ᠵᠠᠭ	зарлиг
ч, ц	ᠴᠠ, ᠴᠡ	ᠴᠠᠭ	ᠴᠠᠭ	цэрэг
я	ᠶᠠ, ᠶᠡ	ᠶᠠᠭ	ᠶᠠᠭ	явган
р	ᠷᠠ, ᠷᠡ	ᠷᠠᠭ	ᠷᠠᠭ	тавиур
л	ᠯᠠ, ᠯᠡ	ᠯᠠᠭ	ᠯᠠᠭ	лав
с	ᠰᠠ, ᠰᠡ	ᠰᠠᠭ	ᠰᠠᠭ	салгах
ш	ᠱᠠ, ᠱᠡ	ᠱᠠᠭ	ᠱᠠᠭ	шувуу

Барын болон ойрад монгол хувилбарт хэлний хойгуур хэлэгдэх гүн угийн, дуутай хамжих “γ” гийгүүлэгчийг гүн бус угийн, дуутай хамжих “g” гийгүүлэгчээс ялгаж бичсэн байх бөгөөд эдгээрийг тус судруудад харилцан адилгүй тэмдэглэсэн сонирхолтой онцлог харагдаж байна. Жишээлбэл:

БАРЫН ЭХ				ОЙРАД МОНГОЛ ГАР БИЧМЭЛЭХ			
Гүн угийн, дуутай хамжих “γ”		гүн бус угийн, дуутай хамжих “g”		Гүн угийн, дуутай хамжих “γ”		гүн бус угийн, дуутай хамжих “g”	
“γ”	ᠭᠦᠨᠭᠡᠨ ᠭᠡᠨᠭᠡᠨ ᠭᠡᠨ	“g”	ᠭᠡᠨᠭᠡᠨ ᠭᠡᠨᠭᠡᠨ ᠭᠡᠨ	“γ”	ᠭᠡᠨᠭᠡᠨ ᠭᠡᠨᠭᠡᠨ ᠭᠡᠨ	“g”	ᠭᠡᠨᠭᠡᠨ ᠭᠡᠨᠭᠡᠨ ᠭᠡᠨ

Төвөд үсгээр үгчлэх зарчим алгуур аажмаар нарийсан сайжирч байсан боловч, тусгай дүрэм бичиг байгаагүй, гагцхүү уламжлалаар тогтсоор ирсэн учир хөдөлшгүй болсон тийм зарчим бүрмөсөн тогтож чадаагүй байсныг (Пагба, 2009: 227) дээрх хоёр хувилбараас энэ мэтээр илэрхий харж болохоор байна.

Төвөд үсгээр монгол үгийг үгчлэн буулгахдаа төвөд-ойрад гар бичмэл хувилбарт тухайн үгийн үеийн заагт цэг (·) тавьж өгсөн бол барын хэвлэлд цэг (·) тавьсан байхаас гадна холбоо үг байгаа тохиолдолд давхар цэг (··)-ээр тэмдэглэсэн онцлог харагдаж байна. Жишээ нь: бар. *ᠰᠡᠭᠡᠨᠭᠡᠨᠭᠡᠨ* (тогтоол ус), *ᠡᠭᠡᠨᠭᠡᠨᠭᠡᠨ* (эхний утга) гэх мэт.

Эцэст нь тэмдэглэхэд, төвөдийн уламжлалт боловсрол төгс эзэмшсэн, монгол бичгийн мэргэд Буддын шашны салбарт үлэмжхэн олон гарч тухайн үеийн эрдэм ухааны бүх чиглэлээр буюу их бага таван ухааныг судлахдаа монгол ахуй нөхцөлд ээнэгшүүлэн боловсруулж (Шагдарсүрэн, 2003: 273) шинэ шинэ баримт сэлтийг нэмэн баяжуулж, нутаг нутгийн онцлогтоо тохируулсаар ирсэн байдгийн нэгэн жишээ болсон “*Нэр утгыг тодотгогч сарны гэгээн гэрэл хэмээх дохионы бичиг оршвой*” нэрт төвөд-ойрад гар бичмэл хоёр хэлний толь бичиг нь үсэг зүй, авиа зүй, үг зүй, үгийн сангийн хувьд тухайн үеийн ойрад нутгийн аялгууны онцлогийг буулгахдаа зүгээр ч нэг үгчлэн хуулж буулгасангүй, харин ч тод үсгийн зөв бичих зүй, ойрад нутгийн аялгууны үгсийн дуудлагыг баримталсан зэрэг онцлогууд харагдаж байна.

Барын болон гар бичмэл хувилбарт монгол хэлний эгшиг, гийгүүлэгч авиаг төвөд үсгийн махбодоор оноосныг харахад, бичигч бүр өөр өөрөөр харилцан адилгүй галигласан байгаа нь төвөд үсгээр галиглах зарчимд нарийн тогтсон дүрэм журам хараахан байсангүй бололтой. Гэвч ингэж төвөд үсгээр монгол үгийг галиглан бичиж ирсэн нь тухайн үеийн бичгийн хэлэнд хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгарч байсан ба монгол

бичгээ сайн мэдэхгүй, төвөд үсэг бичиг мэдэх хүмүүсийн хоорондох бичгийн хэлний үүргийг маш сайн гүйцэтгэсэн нь дамжиггүй.

Ном зүй

“Ner-e udq-a-yi todudqayci saran-u gegen gerel kemegdekъ dokiyan-u biçig orusiba”, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Монгол номын хөмрөг, Дугаар: А-0975, Бээжин бар, 2 мөр, х.62.

Алшаа лхаарамба Агваандандар 2018: Эрхлэн хэвлүүлсэн Б.Мөнхөө, На.Сүхбаатар, Нэр утгыг тодотгогч сарны гэгээн гэрэл хэмээх дохионы бичиг оршвой. УБ., 2018. 229 тал.

Бадамдорж, Батзаяа 2016: *Бадамдорж Б., Батзаяа Г.* Дөрвөд аялгууны толь. Тод номын гэрэл төв, УБ., 2016. 186 тал.

Батдорж 2019: *Батдорж Ц.* Дөрвөлжин бичгийн тогтолцоо дахь эр, эм гийгүүлэгчийн учир. //Дөрвөлжин үсэг-750 олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2019. -14.

Бүрнээ 2018: *Бүрнээ Д.* Агваандандар бол толь бичгийн уурхай гэж хэлж болох том эрдэмтэн мөн. // Эх хэл бичиг. УБ., 2018. №1 дугаар 21, х.5-7.

Гантогтох 2011: *Гантогтох Г.* Буриад аялгууны толь, УБ., 2011. 780 тал.

Даваасүрэн 2018: *Даваасүрэн Д.* Лхаарамба Агваандандарын найруулсан дохионы хоёр бичгийн тухай. // Эх хэл бичиг, УБ., 2018. №1 дугаар 21, х.11-18.

Дорж 2009: *Дорж Ц.*Төвөд монгол дохионы бичиг, түүвэр нэрсийн тухай (монгол бичгээр). //Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурлын эмхэтгэл, I боть, УБ., 2009. х.94.

Ишдорж 1959: *Ишдорж.* Төвөд монгол дохионы бичиг, УБ., 1959. 935 тал.

Лувсанбалдан 1975: *Лувсанбалдан Х.* Тод үсэг, түүний дурсгалууд. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, УБ., 1975. 356 тал.

Мөнхсайхан 2020: *Мөнхсайхан С.* МНТ-ны үгийг эшлэн үзүүлсэн толь. УБ., 2020. 1522 тал.

Отгонбаатар, Цендина 2014: *Отгонбаатар Р., Цендина А.Д.* Монгол үсэг бичгийн дээж. М., 2014. 221 тал.

Пагба 2009: *Пагба Т.* Төвөд үсгээр үгчилсэн монгол ном зохиол.//Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурлын эмхэтгэл, I боть, УБ., 2009. х.218-229.

Самбуудорж 2002: *Самбуудорж О.* Монгол хэлний ойрад аялгууны фонемын тогтолцоо. – ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, УБ., 2002. 175 тал.

Толь бичиг судлалын асуудалд 2008: ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, УБ., 2008.235 тал.

Төмөртоогоо 2018: *Төмөртоогоо Д.* Агваандандар лхаарамбын хэл шинжлэлийн бүтээл.// Эх хэл бичиг, УБ., 2018. №1 дугаар 21, х.8-10.

- Түвшинтөгс 2008: *Түвшинтөгс Б.* Монгол, манж хоёр хэлний толь бичгийн тухай.// Толь бичиг судлалын асуудал, ШУА, Хэл зохиолын хүрээлэн. УБ., 2008. х.113-133.
- Чулуунбаатар 2002: *Чулуунбаатар Л.* Нүүдэлчин монголчуудын үсэг бичгийн соёл. УБ., 2002. 251 тал.
- Шагдарсүрэн 2003: *Шагдарсүрэн Ц.* Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 2003. 304 тал.
- Шагдарсүрэн 2001: *Шагдарсүрэн Ц.* Монголчуудын үсэг бичгийн товчоон. УБ., 2001. 300 тал.